# УЛААНБААТАР
## хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны
## ТОГТООЛ

196 7. оны . 10-р сарын 19 ны өдөр Дугаар 258 Улаанбаатар хот

БОЛЬНИЦ БАЙГУУЛАХ ТУХАЙ.

Хотын дотор сүүлийн үед бага насны хүүхдийн уушигны үрэвсэл өвчин ихсэж, даруй арга хэмжээ авах явдал шаардагдаж байгааг харгалзан хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ НЬ:

I.Сүхбаатарын районы 50 ортой хүүхдийн ашиглагдаагүй больницын хийдэгдэж байгаа төсөв орон тоонд нь зохицуулан Октябрийн районд 50 ортой хүүхдийн больницыг I0-р сарын 25-ны дотор байгуулан ажиллуулахыг хотын Эрүүлийг Хамгаалах Газар /м.ШАГДАРСҮРЭН/-д зөвшөөрсүгэй.

2.Хүүхдийн больницын төсөв орон тоог шилжүүлж өгөхийг хотын санхүүгийн хэлтэс /м.ЦЭРЭНПИЛ/,Хөдөлмөр цалин хөлсний товчоо /м.СЭДБАЗАР/ нарт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА Д.ЦЭДЭВ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.ДАМДИНСҮРЭН

Нийлсэн. [signature]...
6%-ц-А.8I3487.